

Гадаад харилцааг эдийн засагжуулах их гүрнүүдийн бодлого ба Монгол улс

Д.Уламбаяр, Т.Уянга*

This article is talks about a macro analysis on economization of foreign policies of super and rising powers as a global trend and an Agenda for Economization of Mongolia's Foreign relations and its outcomes.

Key words: Economization of foreign relations, economization of foreign policy, GDP, PPP-purchasing power parity, diplomacy, economic diplomacy

* * *

Оршил



Дэлхийн эдийн засаг даяаршиж, улс орнуудын харилцан хамаарал улам бүр гүнзгийрч, хөгжлийн асуудал тэргүүн зэрэгт тавигдах болсон орчин үеийн шатанд дипломат ажиллагаанд худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалт, санхүү, зээл, хөгжлийн тусламж, мэдээлэлийн технологи, хүрээлэн буй орчин, экологийн асуудал шинэ үүрэг гүйцэтгэх болсон явдал юм.

Гадаад харилцааг эдийн засагжуулах нь эдийн засгийн дипломат ажиллагаанд ач холбогдол өгч байгаа хэрэг мөн бөгөөд хөгжлийн асуудал тэргүүн зэрэгт гарч ирсний илрэл юм.

*Д.Уламбаяр. ХИС-ийн Олон улсын харилцаа, Нийгэм судлалын сургуулийн захирал
Т.Уянгаа Монгол-ЕХ-ны Түнцлэлийг дэмжих нийгэмлэгийн гүйцэтгэх захирал, төслийн шинжээч

ОЛОН УЛС СУДЛАЛ

Тиймээс эдийн засгийн дипломат ажиллагаа, түүний чухал бүрэлдэхүүн хэсэг болсон гадаад бодлогыг (мөн гадаад харилцааг) эдийн засагжуулах үйл явц дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага болсоор байна.

2013 оны 2 дугаар сарын 12-нд шинэчилэн баталсан ОХУ-ын Гадаад бодлогын үзэл баримтлалын “Орчин үеийн дэлхий ертөнц ба ОХУ-ын гадаад бодлого гэсэн бүлэг”-ийн нийтлэг үндэслэлд заахдаа: дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал геополитикийн орчинг гүнзгий өөрчлөгдөхөд хүргэсэн хүчирхэг хөдөлгүүр болж, энэ нь орчин үеийн олон улсын хөгжлийн үндсэн шинж болж байна гээд дэлхийн эдийн засаг, улс төрд уламжлалт Өрнөдийн улсуудын голлох үүрэг багассаар байгаа бөгөөд дэлхийн хүчний болон хөгжлийн харьцаанд дахин хуваарилалт явагдаж, Ази руу буюу тэр дундаа Ази-Номхон далайн бүс нутаг руу шилжиж байна гэжээ.¹

PricewaterhouseCoopers олон улсын судалгааны байгууллагаас 2013 оны 1 дүгээр сард гаргасан «2050 оны Дэлхий Ертөнц. БРИКС болон бусад улсууд: хэтийн төлөв, сорилт, боломж» нэртэй судалгаагаар 2017 он гэхэд БНХАУ ДНБ-ийн худалдан авах чадавхийн үнэлгээгээр (PPP) АНУ-ыг тэргүүлж дэлхийн хамгийн том эдийн засаг болох бол 2050 он гэхэд Энэтхэг улс дэлхийн гуравдахь том эдийн засаг, мөн Японыг Бразил гүйцэж түрүүлсэнээр 4 дүгээр байрт орох урьдчилсан дүгнэлт хийжээ. Мөн ДНБ-ийн PPP үнэлгээгээр ОХУ 2020 оноос өмнө Европын хамгийн том эдийн засаг болох судалгаа гарчээ. 2020 оныг хүртэлх судалгаагаар Малайз, Индонези, Вьетнам зэрэг улсууд илүү хямд өртөгтэй бүтээгдэхүүнийг нийлүүлэх бол Хятад, Бразил, Орос нь дэлхийн томоохон хэрэглэгчийн зах зээл болох ажээ. Тиймээс Хятад, эсвэл Энэтхэг руу гарах гарц нь Малайз, Индонези, Вьетнам байх бол, Орос руу гарах гарц нь Польш байх ажээ.²

Монгол Улс дэлхийн хамгийн хурдацтай хөгжиж буй бүс нутагт оршиж, мөн геополитикийн хамгийн өвөрмөц газарзүйн байршилтай, дэлхийн эдийн засгийг ирээдүйд тодорхойлох мөнхийн хоёр

¹Концепция Внешней Политики Российской Федерации. М.: 2013

²World by 2050. The BRICS and Beyond: Prospects, Challenges and Opportunities. PricewaterhouseCoopers. January, 2013

хөрштэйгээ зэрэгцэн хөгжиж буй хувьд хөгжлийн стратегийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга замаа нарийвчлан тодорхойлж, чингэхдээ өөрийн улсын эдийн засгийн харьцангуй бие даасан байдлыг хангах шаардлагыг онцгой анхааралдаа авах ёстой болж байна. Үүний тулд Монгол Улсын эдийн засгийн дипломат бодлогын чухал бүрэлдэхүүн хэсэг болсон гадаад харилцааг эдийн засагжуулах чиглэлд онцгой ач холбогдол өгөх шаардлагатай болов.

Гадаад бодлого болон гадаад харилцааг эдийн засагжуулахуй

Гадаад бодлогыг эдийн засагжуулах тухай ойлголт бол Өрнөдийн улс орнуудын хувьд шинэ зүйл биш юм. Учир нь тэд өөрсдийн худалдаа-эдийн засаг, бизнесийн эрх ашгийг гадаад бодлогоороо дамжуулан гүйцэтгэж ирсэн бөгөөд энэ нь үндэсний аюулгүй байдлын язгуур ашиг сонирхлын асуудлын нэг болдог. Жишээ нь: АНУ, Их Британий гадаадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчдийн газрын ажилчдын дийлэнхи нь зөвхөн худалдаа-эдийн засгийн асуудал хариуцдаг байна. Бүр ХХ зууны эхээр АНУ-ын өсөн нэмэгдэж байсан эдийн засгийн хүч чадавх дипломат бодлогод нь шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж эхэлсэн байна. АНУ-ын Ерөнхийлөгч Теодор Рузвельтын Засгийн газрын олон улсын хэмжээнд зуучлах, хүчээр түрээ барих, «ойлгуулах, ташуурдах хос бодлогыг» «долларын дипломат» ажиллагаагаар өөрчлөн явуулах болсныг шинээр сонгогдсон Ерөнхийлөгч Уильям Тафт 1912 оны 12 дугаар сард Конгресст өргөн барьсан илгээлт нотлов. Уг илгээлтэд: «Одоогийн Засгийн газрын дипломат бодлого орчин үеийн худалдааны харилцааны шаардлагад зохицож байхыг шаардаж байна. Энэ бодлого нь доллар сэлэм, жадны үүргийг гүйцэтгэх ёстой» гэсэн байна. Сайхь бодлого нь хоёр талтай байсан агаад нэгд, гадаадад байрлуулсан *Wall Street*-ийн хөрөнгийг³ дипломат арга хэрэгслээр хамгаалах, *хоёрт*, гадаад дахь хөрөнгө оруулалтын таагай нөхцлийг бүрдүүлэхэд үлэмж анхаарч *Wall Street*-ийн доллараар АНУ-ын гадаад бодлого, дипломат ажиллагааг дэмжихэд оршиж байв.⁴ Bretton Woods-ын систем бол дэлхийн II дайны дараа тогтсон олон улсын эдийн засгийн шинэ дэг

³ ХХ зууны эхээр гадаад байршсан АНУ-ын нийт хөрөнгийг *Wall Street*-ийн хөрөнгө гэж нэрлэж байжээ.

⁴ Д.Уламбаяр. «Эдийн засгийн дипломат ажиллагаа: онол-түүх, орчин үеийн зангилаа асуудалд» "Олон улс судлал" сэтгүүл. ОУСХ, ШУА, 2011. №2 (92) 56-72 дахь тал, 2011. №3 (93) 72-88 дахь тал

ОЛОН УЛС СУДЛАЛ

журмын суурь үндэс юм. Энэ системээр ОУВС, Шинэчлэл, хөгжлийн олон улсын банк буюу өнөөгийн Дэлхийн банкны групп, Тариф, худалдааны Ерөнхий хэлэлцээр буюу өнөөгийн ДХБ-ны үндэс суурь тавигдаж, АНУ-ын үндэсний мөнгөн дэвсгэрт дэлхийн валют болсон нь АНУ-ын эдийн засгийн дипломат ажиллагааны том ялалт, гадаад бодлогыг эдийн засагжуулахын тод жишээ болсон юм. Маршаллын төлөвлөгөө бол тэрхүү системийн шууд үргэлжлэл болсон гэж хэлж болно.

Харин пост коммунист улсуудын хувьд энэ нь шинэ томъёолол байв. 2004 оны 5 дугаар сарын 18-нд ОХУ-ын Гадаад хэргийн орлогч сайд А.И.Денисов мэдэгдэхдээ: «Глобалчлалын нөлөө болон олон улсын өрсөлдөөн нэмэгдэж байгаатай холбогдон дэлхийн олон улс орнууд гадаад бодлогоо эдийн засагжуулах идэвхтэй үйл ажиллагаа явуулах болов. ОХУ ч олон улсын энэ чиг хандлагатай хөл нийлүүлэх шаардлагатай. ОХУ-ын ГХЯ гадаад улс орнуудтай харилцахдаа худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлыг нэн тэргүүнд тавихад илүү их анхаарч байна. Сүүлийн жилүүдэд манай улсын пүүс компаниуд Европ, Ази, АНУ, Африкийн зах зээлд гарах нь өргөжих болов.

Тэдгээрийн дунд нүүрсустөрөгч, металл, газрын тос, байгалийн хий болон мод нийлэгчдээс эхлээд өндөр технологи, нэмэгдсэн өртөг шингэсэн бүтээгдэхүүн экспортлогчид байгаа бөгөөд гадаадад компани болон хувьцаа худалдан авч байна. Энэ хандлага цаашид ч нэмэгдэх хандлагатай байна” гэжээ 2008 оны 8 дугаар сард ОХУ өөрийн бүрэлдэхүүнд байсан Гүрж улстай 5 өдрийн дайн хийсэн. Үүнээс үндэслэн хуучин ойрын хөршүүдтэйгээ харилцах улс төрийн эв найрамдалт үе өнгөрснийг бүрнээ ойлгож, харин тэдгээр улсыг эдийн засгийн аргаар буюу гадаад бодлогоо эдийн засагжуулах далбаан дор тэнд өөрийн эдийн засгийн нөлөөгөө бататгах үйл ажиллагааг ялангуяа 2008 оноос хойш улам эрчимжүүлж байна гэж Өрнөдийн судлаачид үзэж байгаа юм. Үүнийг Украины нутаг дэвсгэрийн салшгүй хэсэг Крымын хойгийг өөртөө нэгтгэсэн бодлого, үйл ажиллагаа дахин ноцтой харуулав. ОХУ Крымын хойгт үлэмж ач холбогдол өгч байгаа нь тус хойгт нефтийн нөөц ойролцоогоор 47 сая тонн, хий 165,3 тэрбум

шоо метр байгаа хэмээн ОХУ-ын Байгалийн нөөц, экологийн сайд Сергей Е.Донской 2014 оны 4 дүгээр сард мэдэгдэв. “Нийтдээ сайхь бүсэд нүүрсустөрөгчийн 44 орд, түүнээс долоон хийн орд, нефтийн 10 орд газар байгаа юм” гэж Оросын Байгалийн нөөц, экологийн сайд тайлбарлав. С.Е.Донской тэмдэглэснээр, өнөөдрийн байдлаар Хар тэнгисийн эх газрын үргэжлэл болох далайн ёроолд хийн таван орд, хийн хольцийн гурван орд, мөн Азовын тэнгисийн ёроолд хийн зургаан ордын хайгуул хийгдсэн гэснээс тодорхой байгаа юм. Хар тэнгисийн флот, хойгийн геополитикийн байршил нэн чухалд тооцогдож байгаа нь ойлгомжтой.

Аюулгүй байдлыг эдийн засагжуулахуй: Гадаад бодлогыг эдийн засагжуулах төдийгүй мөн аюулгүй байдлыг эдийн засагжуулах тухай ойлголт сүүлийн үед шинээр гарч ирэв. 2013 оны 5 дугаар сард Шведийн нийслэл Стокгольм хотноо болсон олон улсын бага хурал «Германы Аюулгүй байдлын бодлогыг эдийн засагжуулах нь: Герман-Оросын харилцааны талбар дээр»⁵ гэсэн нэртэй болсон байна. 2000 онд В.Путин ОХУ-ын Ерөнхийлөөр сонгогдсоноос хойш гадаад худалдаагаа өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах, дэлхийн зах зээл дээр газрын тос, байгалийн хийн талаар гол тоглогч гэдгээ бодитой харуулж, энэ чиглэлд үлэмж анхаарал хандуулсаар ирэв. Хэдий ОХУ-д нэг хүний гарт эрх мэдэл хэт төвлөрөх, хүний эрхийг хөсөрдүүлэх, чөлөөт хэвлэлийг хавчин боох, ардчилалыг зарчмыг алдагдуулах, зарим хөрш улсууд, тухайлбал Гүрж, Украинд заналхийлж байгаа хэдий ч ХБНГУ-ын ОХУ-д хандах бодлого нь *Европын болон дэлхийн аюулгүй байдал Оросын эсрэг, эсвэл Орос улсгүй байж таарахгүй* гэдгийг иш үндэс болгож байна. Орос-Германы хоорондын аюулгүй байдлын асуудал дээр олон санал санаачлага гарч байсан хэдий ч хэрэгжсэн үр дүн ихээхэн чамлалттай байгаа ажээ. Гэхдээ 2008 онд АНУ-ын Ерөнхийлөгч Д.Медведевийн дэвшүүлсэн Шинэ Евро-Атлантын аюулгүй байдлын системийн хэлэлцээг буй болгох шинэлэг санаачилагыг ЕХ-ны улсуудын ихэнх нь дэмжээгүй байхад ХБНГУ

⁵Karolina Libront. Economization of German Security Policy. The Case of German-Russian relations. Working paper, 17th Annual International Conference on Economics and Security. SIPRI. Stockholm, Universitus Varsoviensis 14-15 June 2013

ОЛОН УЛС СУДЛАЛ

дэмжсэн байдаг. Нөгөө талд Орос-Германы худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа улам бүр өргөжин хөгжсөөр хоёр талын харилцааг голлон тодорхойлох хүчин зүйл болсон байна. Хоёр улсын стратегийн хамтын ажиллагаа ялангуяа эрчим хүчний салбар дахь эдийн засгийн хамтын ажиллагаагаар тодорхойлогдож байна.⁶

Сүүлийн үед АНУ-ын зарим судлаачид 2008 оны дэлхийн санхүүгийн хямралын дараа АНУ нь хямралын дараах дэлхий нийтийн түгээмэл асуудлыг шийдэх шинэ гадаад бодлогын парадигм буюу загвар хэрэгтэй байгааг онцолж байна. Энэхүү парадигмын гол үндэс нь гадаад бодлогын цөмд эдийн засгийн бодлогыг аваачиж тавихыг хэлж байгаа юм. Учир нь *нэгд*, АНУ-ын санхүүгийн хүндрэлтэй байдал дэлхийд өөрийн глобал үйл ажиллагаагаа явуулахад нь гол саад болж байгаа бөгөөд *хоёрт*, Хятадын эдийн засгийн үсрэнгүй хөгжил, ОХУ-ын эдийн засгийн сэргэлтийн амжилт нь АНУ-ын гадаад бодлогын гол зорилго нь ДНБ-ээ өсгөх явдал гэж үзэхэд хүргэв.⁷ АНУ гадаад бодлогоо дахин шинэчлэх шаардлагатай бөгөөд дотоод болон глобал эдийн засгийн асуудлыг хамарсан шинэ чиглэлийг буй болгох хэрэгтэй талаар судлаачид үзэж байна. АНУ-ын засаг захиргаа ч гадаад бодлогын зорилтуудын тухайд шинэ сэтгэлгээгээр хандах шаардлага нь дипломат ажиллагаа уламжлалт үндэсний аюулгүй байдал, олон улсын харилцаа зэрэг тулгамдсан асуудалд чиглэгдэхийн зэрэгцээ эдийн засгийн асуудалд анхаарлаа төвлөрүүлэх болов. Үүний нэгэн тодорхой илрэл нь 2011 онд АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Хиллари Клинтон АНУ-ын бодлогын талаарх үндсэн илтгэлдээ өгүүлэхдээ: “АНУ-ын гадаад бодлогын хөтөлбөрийн цөм нь *economic statecraft* буюу төрийн үйл ажиллагааг эдийн засгийн арга барилаар явуулах ур чадвар”-ыг эзэмшихэд оршино⁸ гэжээ. Энэ бодлогын үр дүн нь 2013 онд АНУ-ын ДНБ 17.4 их наяд ам. долларт хүрч өссөн явдал бөгөөд харин БНХАУ-ын эдийн засгийн хөгжлийн хурдац мэдэгдэхүйц буурч, ДНБ нь 11.1 их наяд ам. доллараас 9.4 ам. долларт

⁶Memorandum. Meeting of Chancellor Angela Merkel and Dmitry Medvedev on 4-5 June 2010 in Meseberg, Germany

⁷Leslie H. Gelb. «GDP Now Matters More Than Force: A U.S. Foreign Policy for the Age of Economic Power» Council on Foreign Relations. November/December 2010

⁸Secretary of State Hillary R. Clinton's Speech at Economic Club of New York, “On Economic Statecraft”. October 14, 2011, New York

хүрч, өсөлтийн дундаж 7.5 хувьд хүрч буурав.

АНУ, түүний холбоотнууд хүйтэн дайнд ялалт байгуулсны дараах үеэд АНУ-ын гадаад бодлого нь дэлхий дахинд хүний эрх, эрх чөлөө, ардчилалыг сэргээн баталгажуулах, чөлөөт зах зээлийн эдийн засгийн харилцааг түгээн дэлгэрүүлэх тухай хөтөлбөр байсан бол, эдүгээ улс орнуудын болон дэлхийн эдийн засгийг хэрхэн зөв менежментээр залж, удирдан чиглүүлэх тухайд илүү анхаарлаа хандуулж байна. 2008 оны дэлхийн санхүүгийн хямрал нь глобалчлал нь зөвхөн олон улсын эдийн засгийн өсөлтийн хөдөлгөгч хүч, хөгжлийн өргөн боломж төдийгүй мөн ноцтой эрсдэлд хүргэж байгааг харуулав. Тиймээс АНУ-ын дэлхийн⁹ тавцан дахь гадаад бодлогын гол зорилго нь глобал эдийн засгийг дахин тэнцвэржүүлж, мөн хямралын салшгүй нэг хариу сөрөх үйлдэл болох протекционист бодлоготой тэмцэх явдал болж байгаа ажээ.

Европын Холбооны интеграци томоохон сорилттой тулгарч байгаа нь олон улсын харилцаа, глобал эдийн засгийн харилцаанд интеграцчлалын үйл явц цорын ганц боломж биш гэдэг нь тодорхой болов. ЕХ-ны төсвийн зөв бодлого, өрийн уян хатан менежмент, онцгой байдлын үеийн шуурхай байдал, урьдчилан сэргийлэх эдийн засгийн дипломат ажиллагаа нь аюулгүй байдлыг эдийн засагжуулахтай шууд холбогдсон юм.

1990 оны 12 дугаар сард Ром хотноо болсон Европын Зөвлөлийн хуралдаанаар ЗХУ-д өрнөсөн өөрчлөн байгуулалтын эдийн засгийн шинэчлэлийг дэмжих зорилгоор ТАСИС хөтөлбөрийг бий болгон хэрэгжүүлэхээр шийдсэн нь ЗХУ-ын тогтвортой байдал Европт төдийгүй дэлхий дахины энх тайваныг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзсний шууд үр дүн байв. Энэхүү техникийн тусалцааг мэдлэг (Know-how) дамжуулах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх гэсэн үндсэн хоёр хэлбэрээр олгохоор тогтож, 1991 оны 7 дугаар сард баталсан 2157/91 тоот тогтоолоор Европын Зөвлөлөөс 1991-1993 онд хэрэгжих ТАСИС хөтөлбөрийн журмыг батлан гаргасан боловч

⁹ Gregory Chin. «The Economic Diplomacy of the Rising Powers»-“The Oxford Handbook of Modern Diplomacy. York.: 2013

ОЛОН УЛС СУДЛАЛ

ЗХУ задарсанаар хэрэгжиж чадаагүй ажээ. 1991 оны сүүлчээр ЗХУ задарсаны дараа ТАСИС хөтөлбөр нь ОХУ болон ТУХН-ийн орнуудын зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үйл явцыг дэмжихэд чиглэгдэх болсон байна. 1993-1995 онд ТАСИС хөтөлбөрийн хүрээнд тусламж үзүүлэх тухай журамд заасанчилан ТАСИС хөтөлбөрийн зорилго нь ЗХУ задарсаны үндсэн дээр шинээр буй болсон тусгаар тогтносон орнуудад зах зээлийн эдийн засагт шилжихэд нь туслах, үүний зэрэгцээ ардчилалыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх явдал байв. 1996 онд гаргасан ТАСИС-ийн ерөнхий журамд энэ хоёр зорилгод тэнцүү ач холбогдол өгөх болж, ардчилалыг бэхжүүлэхэд нь туслах явдлыг хавсарга маягтай үздэг байснаа больсон байна.

Түүнчлэн Хятад, Оросын эдийн засгийн хөгжил, цаашилбал олон туйлт (multi-polarity) ертөнц төлөвшөх чиг хандлага глобал аюулгүй байдлыг тогтворгүйжүүлэх, дэлхийн шинэ дэг журам бүрэлдэх үйл явцад сөрөг нөлөө үзүүлэх болов гэж америк, английн судлаачид үзэж байна.¹⁰

Монгол Улсын өмнөд хөрш Хятадын хувьд 3 их наяд ам. долларын валютын нөөцтэй болсон нь олон улсын зээл, тусламжаа юаниар олгох бодлогод шилжих бололцоог олгож буй бөгөөд мөн гадаад худалдааны төлбөр тооцоог юаниар гүйцэтгэх болов. БНХАУ Төв Ази, Алс Дорнод, Африк, Латин Америк, Дорнод Европт геозэдийн засгийн шинэ орон зай буй болгох, улмаар өргөжүүлэх зүгт ихээхэн хүчин чармайлт тавьж эхлэв.

Ийнхүү дээрх үйл явц, чиг хандлага АНУ, ОХУ, ЕХ, БНХАУ зэрэг их гүрнүүдийг гадаад бодлого, аюулгүй байдлаа эдийн засагжуулах тухай ярихад хүргэж байна.

Монгол Улсын гадаад гарилцааг эдийн засагжуулахуй: Глобалчлалын үйл явц дэлхийн улсуудын хамтын ажиллагааг улам өргөжүүлээд зогсохгүй мөн бие биеэсээ улам ихээр хамааралтай болгосон билээ. Орчин үед аливаа улс орон оршин тогтнож, хөгжин дэвшихийн тулд өөрийн эдийн засгийн нөөц, чадавхиа бүрэн дүүрэн

¹⁰Гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөр. ГХЯ. УБ.: 2009

ашиглахын тулд өгөөжтэй гадаад эдийн засгийн хамтын ажиллагаа шаардлагатай. Иймд Монгол Улс гадаад бодлогоо хэрэгжүүлэхдээ гадаад харилцаагаа эдийн засагжуулах нь нэн зайлшгүй чухал болж байна.

Монгол Улсын Засгийн газар Гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 324 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан нь дээрхийн тодорхой илрэл хэмээн үзэж байна.

Гадаад харилцааны үр өгөөжийг улам нэмэгдүүлэх, гадаад харилцааг эдийн засагжуулах шаардлагатай уялдуулан, мөн 2010 онд шинэчлэгдсэн Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцүүлэн 2011 онд Гадаад бодлогын үзэл баримтлалыг улс орны гадаад орчны өөрчлөлт болон дотоодын шинэ зорилттой холбоотой зарим заалтыг нэмж шинэчлэн баталсан байна.

2009 оны 10 дугаар сард анх удаа зохион байгуулагдсан «Монгол Улсын гадаад харилцааг эдийн засагжуулахад тулгамдсан асуудлууд» сэдэвт үндэсний зөвлөлгөөн дээр гадаад бодлогыг эдийн засагжуулах зорилго нь Монгол улсын хөгжлийг хөдөлгөгч гол хүчин зүйл болгоход оршино. Энэ бодлого нийгмийн бүхий л хүрээнд нэвтрэх ёстой гэдгийн онцлон тэмдэглэсэн байна.

Монгол Улсын гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөрийн зорилго нь гадаад харилцааны арга хэрэгслээр эдийн засгийн өгөөжийг дэмжихэд оршино. Мөн Монгол Улс гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлснээр ДНБ-ий өсөлтөд гадаад бодлогын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлж, шууд болон шууд бус үйлчлэлтэй болгон Гадаад харилцааны сайдын төсвийн багцын нэгж төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлнэ гэж заасан байна. Уг хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт нь гадаад худалдааны эргэлт, түүний дотор экспортын өсөлт, гадаадын хөрөнгө оруулалтын өсөлт, ажлын байрны нэмэгдсэн байдал, тоон үзүүлэлт, нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт болно. 2009-2012 онд дээрх шалгуур үзүүлэлтээр уг хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг дүгнэвэл мэдэгдэхүйц амжилттай хэрэгжсэн дүр төрх харагдаж буй хэдий ч

ОЛОН УЛС СУДЛАЛ

чанарын хувьд шинжвэл зөвхөн нэг салбар буюу уул уурхайн салбар л дийлэнх хувийг эзэлж байна.

Мөн бусад шалгуур үзүүлэлт болох эдийн засгийн өсөлт, нэг хүнд ногдох ДНБ болон ДНБ-ы үзүүлэлтүүд нэг салбарын буюу уул уурхайн салбар эдийн засгийн эргэлтэд орсоноор эерэг гарсан гэж үзэж болохоор байна. Тиймээс уг хөтөлбөрийн хамрах хүрээ бага байгаа болно. Өөрөөр хэлбэл гадаад харилцааг эдийн засагжуулах гэдэг нь зөвхөн ГХЯ-нд л хамааралтай юм шигээр ойлгож огт болохгүй билээ. Уг хөтөлбөрийн дутагдалтай тал нь энэ юм.

Монгол Улсын гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөр нь зөвхөн эдийн засгийн гадаад бодлогын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхийг хэлэхгүй бөгөөд гадаад харилцаанд оролцож буй төрийн бүхий л байгууллага, төрийн өмчит компаниудад хамаатай юм. Эдийн засагжуулах үзэл баримтлал нь улс төр, худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, соёл, хүмүүнлэг, гадаадад байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах, гадаад сурталчилгаа болон олон нийттэй харилцах бодлого зэрэг нийгэм-эдийн засгийн бүхий л салбарыг хамрах ёстой.

Эдүгээ улс төрийн гадаад бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд ч худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа маш их үүрэг гүйцэтгэх болж, энэ нь жижиг эдийн засагтай, их гүрнүүдийн геополитик, геоздийн засгийн ашиг сонирхол тууштай нэмэгдэж буй Монгол Улсын хувьд нэн чухал бөгөөд тиймээс ч *нэгт*, гадаад улс төрийн харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааны нэгдмэл байдал, залгамж шинжтэй, олон тулгуурт, эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмыг хадгалах; *хоёрт*, Их гүрнүүдийн Монгол Улс дахь эдийн засгийн ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх бодлого баримтлах; *гуравт*, эдийн засаг, гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын хэлэлцэл хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхдээ харилцан ашигтай, ил тод байх тухай сайхь хөтөлбөрийн үндсэн зарчмуудыг тууштай баримтлах явдал юм.

Шинжлэх ухаан-технологийн салбарын гадаад харилцааг эдийн засагжуулах нь дэлхийн дэвшилтэд техник, технологийг нутагшуулж, түүний эдийн засгийн өсөлтөд үзүүлэх өгөөж, үр ашгийг нэмэгдүүлэх,

үндэсний өрсөлдөх чадавхийг сайжруулах, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хурдасгахад дөхөм үзүүлэх явдал юм. Мөн нөгөө талаас өөрийн улсын инженер, техникийн мэргэжилтнүүдээ үндэсний хэмжээнд дэмжсэнээр гадаад улсаас хамааралтай салбаруудаа харьцангуй бие даалгаж, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх явдал болно. Дэд болон суурь байгууламж, эдийн засгийн салбарын интеграцчлалыг хөгжүүлэх үндсэн дээр инновацчлалыг эдийн засгийн өсөлтийн нэг хөдөлгөгч хүч болгох явдал гэдэг нь тодорхой билээ.

Мэдээдэл зөвхөн байгууллага, хувь хүн төдийгүй улс үндэстний хувьд хөгжлийн нэг чухал хөдөлгөгч хүчээс болсноос гадна өрсөлдөх давуу талыг олгож байна. Өргөн уудам нутагтай, цөөн хүн амтай, тээвэр, зам харилцаа зэрэг дэд бүтцийн хөгжил сул манай улсад энэхүү боломжийг илүү ихээр ашиглах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, тус хөтөлбөр нь дипломат үйл ажиллагаа, гадаад харилцааны эдийн засгийн хүрээг нь түлхүү хөгжүүлэхээс гадна эдийн засгийн хөгжилд гадаад харилцааны арга хэрэгслэлийг илүү идэвхтэй ашиглахад орших юм. Тиймээс эдийн засгийн хөгжлийн нэгэн тулгуур хүчин зүйл нь гадаад харилцааг үр өгөөжтэй ашиглахад чиглэгдэж байгаа юм.

Монгол Улсын Засгийн газар Гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөр баталсан нь дурдсан чиглэлд чухал алхам болсон ч өргөн утгаар нь авч үзвэл, сайхь хөтөлбөрийг дорвитой хэрэгжүүлж чадаагүй гэж дүгнэж болно. Зөвхөн уул уурхай салбар гадаад харилцааны салбарын дэмжлэгтэйгээр эдийн засгийн үр өгөөжөө өгч эхэлсэн боловч энэхүү салбарт Монгол Улсын үндэсний язгуур эрх ашиг, үндэсний аюулгүй байдлыг орхигдуулсан явдал нь алсдаа улс оронд хохиролтой байхуйц бөгөөд эдийн засгийн ашиггүй үр дүнд хүргэх эрсдэлтэй байна.

Шинэчлэлийн Засгийн газар 2013 оны 5 дугаар сард эдийн засгийн гадаад харилцааны байр суурь, чиг үүргийг Эдийн засгийн хөгжлийн яаманд шилжүүлэх шийдвэр гаргасан нь гадаад бодлогын нэгдмэл байдал, залгамж чанарыг алдагдуулж буйг онцлон тэмдэглэмээр байна.

Аливаа улсын тогтвортой хөгжлийг хангах төсөл, хөтөлбөрийн үр өгөөж урт хугацааны дараа гардаг. Тиймээс улсын гадаад бодлогын нэгдмэл байдлыг хадгалж, залгамж чанарыг хангаж байж, энэхүү “Гадаад

ОЛОН УЛС СУДЛАЛ

харилцааг эдийн засагжуулах” хөтөлбөр амжилттай хэрэгжиж, гадаад харилцааны салбараас орж ирэх эдийн засгийн үр өгөөж бодитой байх болно. Тус хөтөлбөр 2009-2012 оны оноор хэрэгжиж дууссан учир одоогийн Засгийн газар шинээр хөтөлбөр боловсруулж, батлан гаргах шаардлагатай байна.

Эцэст нь тэмдэглэхэд 2013 оноос Монголын эдийн засгийн хөгжлийн хурдац саарч, хөрөнгө оруулалт буурч, бизнесийн үйл ажиллагаа хумигдаж, инфляци өсч, хямралын эрмэгт тулж ирсэн нь гол нь Засгийн газрын бодлого, үйл ажиллагаа, юуны өмнө гадаад харилцааг эдийн засагжуулах бодлогыг алдагдуулсан холбоотой. Тиймээс *нэгд*, гадаад харилцааг эдийн засагжуулах үйл явцыг эрчимжүүлэх, *хоёрт*, урьдчилан сэргийлэх эдийн засгийн дипломат ажиллагаа, *гуравт*, аюулгүй байдлыг эдийн засагжуулах, *тавд*, онцгой байдлын үеийн шуурхай менежментийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.